



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2001 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Жадамбаа овогтой Батцэцэгийг АНУ-ын Денвер хотын Колорадогийн их сургуульд нийгмийн ухааны чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Лхагваа овогтой Ундрамыг Их Британийн Нэгдсэн Вант улсын Шеффельдийн их сургуулийн докторантурт хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр, Төрболд овогтой Мөнх-Оргилыг АНУ-ын Вирджини мужын Редфордын их сургуульд хөгжмийн менежерийн чиглэлээр, Адьяа овогтой Энхжаргалыг Их Британийн Нэгдсэн Вант улсын Кентийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Дүнжүүсарай овогтой Хишигсүрэнг ХВНГУ-ын Бонны их сургуулийн магистрантурт хэл, соёл судлалын чиглэлээр, Сандагдорж овогтой Оюуг АНУ-ын Сан-Францискогийн улсын их сургуульд олон улсын бизнесийн удирдлагын чиглэлээр, Улаан овогтой Ундрамыг Япон улсын Васедагийн их сургуулийн магистрантурт олон улсын харилцааны чиглэлээр, Бира овогтой Янжмааг Япон улсын Токүшимагийн их сургуулийн докторантурт анагаах ухааны чиглэлээр, Дулам овогтой Бум-Очирыг Англи улсын Кембриджийн Их сургуулийн докторантурт нийгэм соёлын антропологийн чиглэлээр, Шаравсамбуу овогтой Уртнасанг АНУ-ын Боулдэр хотын Эдийн засгийн институтын магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Лхагвасүрэн овогтой Тэгшбаяр, Алтанболд овогтой Ганжаргал нарыг 2001-2002 оны хичээлийн жилээс ОХУ-ын Дотоод явдлын яамны Улсын гал түймэртэй тэмцэх албаны академид 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

3. ХБНГУ-ын Карлсрүэгийн их сургуулийн магистрантурт суралцаж буй Авирмэд овогтой Түвшинжаргалын суралцах хугацааг 0,5 жилээр, Украин улсын Львов хотын Политехникийн их сургуулийн аспирантурт суралцаж буй Даланбаяр овогтой Болормаагийн суралцах хугацааг 1 жилээр тус тус сунгасугай.

4. АНУ-ын Денвер хотын Колорадогийн их сургуульд суралцаж буй Дашпунцаг овогтой Хулангийн сүүлийн нэг жилийн сургалтын төлбөр, ОХУ-ын Екатеринбург хотын Техникийн их сургуулийн аспирантурт суралцаж буй Лувсандорж овогтой Жаргалхүүгийн эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

5. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Бамсанда А.ЦАНЖИД